

НИЙСЛЭЛИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН АЖЛУУДЫН ТАЙЛАН

1. Нийслэлийн авто замын гэрлэн дохиотой уулзваруудад иж бүрэн шонг нийлүүлэх, угсарч суурилуулах, засвар үйлчилгээний ажил

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/163, А377 дугаар захирамжийн хүрээнд Авто замын түгжрэлийг бууруулах төсөл арга хэмжээний жагсаалт-ын 27-д заасан “Замын хөдлөгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем”

Төслийн явцын мэдээ: RFID уншигч төхөөрөмжөөр бүрэн тоноглогдох Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Сонгино хайрхан, Баянгол дүүрэг гэсэн нийслэлийн төвийн зургаан дүүргийн гэрлэн дохиотой 138 уулзварын 343 байршилд Г хэлбэрийн шонг бүрэн угсарч дуусгасан. 11 байршилд П хэлбэрийн 11 ширхэг шонг суурилуулж дуусаал байна. НЦХМТГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/509 тоот тушаалаар байгуулагдан ажлыг хүлээн авахаар хуваарийн дагуу ажиллаж байна.



2. Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоодод цахим төлбөр, хураамжийн системийг сайжруулах, төлбөрийн нэхэмжлэх үүсгэх, төлбөрийн нэгдсэн системд холбох, тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил

Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоодын төлбөр, хураамжийн системийг сайжруулах, цахим төлбөрийн систем нэвтрүүлэх, нэхэмжлэх үүсгэх, төлбөрийн нэгдсэн системд холбох, тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил бүрэн хийгдэж дууссан.

Нийслэлийн харьяа нийт 8 шалган бүртгэх товчоод /Баруун түрүүн, Налайх /Хоолт/ налайх тэрэлж, түргэний гол, эмээлт, Гүнт, Гачуурт, Морингийн даваа/-д дугаар таних, чиглэлийн, өрөөний дотрох, орчны хяналтын эргэдэг нийт 57 камер болон бусад тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогсон бөгөөд үүнээс хяналт тавьдаг байнгын ажиллагаатай 4 товчоод /Баруун түрүүн, Налайх Тэрэлж, Түргэний гол, Эмээлт/-ын төлбөр авах цэгт цахим төлбөрийн системийг 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр нэвтрүүлж, одоогоор хэвийн үйл ажиллагаатай явагдаж байна.

Тус төлбөрийн систем нь Зам, тээврийн нэгдсэн ухаалаг системийн дэд систем болон ажиллах зорилготой юм. Төлбөрийн цахим систем нь шалган бүртгэх товчоогоор

нэвтэрч буй тээврийн хэрэгслийн эзэмшигч иргэнд дараах байдлаар нэхэмжлэхийг илгээж төлбөрийг хураана. Үүнд:

1. Хаан, Голомт /Сошэйл пэй/, Худалдаа хөгжлийн банкнуудын төлбөрийн үйлчилгээний аппликейшнд “хот хоорондын авто зам ашигласны хураамж” цэс байрших бөгөөд иргэн тээврийн хэрэгслийн улсын дугаараа бүртгүүлсэн тохиолдолд төлбөр автоматаар хасагдаж төлөгдөнө;
2. Мобикомын “Монпрау” төлбөрийн үйлчилгээний аппликейшнд “замын хураамж” цэс үүссэн бөгөөд иргэн тээврийн хэрэгслээ бүртгүүлснээр монпэй цахим хэтэвчээс болон бүртгүүлсэн арилжааны банкны картаас нь автоматаар хасагдаж төлөгдөнө;
3. Тээврийн хэрэгслийн үйлчилгээний нэгдсэн <https://smartcar.mn/> системд:
 - а. Иргэн арилжааны бүх банкны төгрөгийн картаа холбосноор товчооны төлбөр автоматаар хасагдаж төлөгдөнө;
 - б. Холбосон картын үлдэгдэл хүрэлцэхгүй эсвэл картаа холбоогүй тохиолдолд нэхэмжлэх хэлбэрээр үлдэж дараа төлөлтөөр Qpay-ээр төлөх боломжтой болсон.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Нийслэлээс гарах, орох товчоодын ачаалал багасаж, биет байдлаар төлбөр авах ажиллагааг халж тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношилгоонд хамрагдсан байдал зэрэгт хяналт тавих, цаашлаад зөрчилтэй тээврийн хэрэгслийг илрүүлэх аппликейшнийг бий болгож, цахим төлбөрийн системд олон төрөлт цахим төлбөрийн арга хэрэгслийг нэвтрүүлж, хүний оролцоог багасгах давуу талууд бий болох юм.





3. Газрын зургийн суурь системийг хөгжүүлэх, орон зайн мэдээлэл дээр тулгуурласан авто замын хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн систем хөгжүүлэх, замын хөдөлгөөний нөхцөл байдлын дүн шинжилгээ, тайлан тооцоо боловсруулах

Төслийн явцын мэдээ: Тус ажлын хүрээнд <https://ubmap.ulaanbaatar.mn/> системийг хөгжүүлсэн.

Тус систем нь:

- Автобусуудын байршлын мэдээллийг харах бодит цаг дээрх GPS-ны мэдээлэл
- Зорчилтын мэдээлэл
- Дамжин суух буюу дамжилтын мэдээлэл
- Байршлын мэдээлэл болон атрибутын мэдээлэл
- Товчоодын мэдээлэл дамжуулах сервис
- Тээврийн хэрэгслийн мэдээлэл
- RFID уншигчийн байршил болон атрибутын мэдээлэл

- 2-3 эгнээ замын агшны хурдны зөрчил болон бусад зөрчил илрүүлэлтийн системийн жишээ дата
 - Гэрлэн дохионы байршил болон атрибутын мэдээлэл
 - Зогсоолын байршил болон атрибутын мэдээлэл
- Сервис , мэдээллүүдийг харуулсан модултай.



4. Системийн архитектур, мэдээлэл солилцох стандарт боловсруулах, Системийн ерөнхий шаардлага боловсруулах, процессын шинжилгээ хийх, эрсдлийн үнэлгээ хийх, мэдээллийн аюулгүй байдлыг боловсруулах зөвлөх үйлчилгээ

Төслийн явцын мэдээ:

"Зам тээврийн нэгдсэн ухаалаг систем нэвтрүүлэх" дэд төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Зам тээврийн нэгдсэн ухаалаг системийг хууль эрх зүйн орчинд нийцүүлэн зөв, оновчтой төлөвлөхийн тулд системийн энтерпрайз архитектур буюу мэдээлэл солилцох нэгдсэн тогтолцоог боловсруулах, Улаанбаатар хотын авто замуудаар зорчиж буй авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, замын ачаалал, тээврийн хэрэгслийн зөрчлийн мэдээллийг хянах, төлбөртэй зогсоол болон авто замын төлбөр хураалт, түүний

хяналтын үйл ажиллагааг автоматжуулах дэд системүүдийн нэгдсэн төлөвлөлт, архитектур зураглал гаргах, мэдээлэл солилцох стандарт боловсруулж, процессын шинжилгээ хийж, журам боловсруулан эрсдлийн үнэлгээ хийх ажлууд хийгдэж байна.

5. Нийслэлийн авто замын 14 байршилд П шон угсарч суурилуулах, камер болон RFID төхөөрөмжөөр тоноглох, тохиргоо хийх, шилэн кабелин сүлжээнд холбох ажил

Төслийн явцын мэдээ: Нийслэлийн авто замын 14 байршилд П шон угсарч суурилуулах, камер болон RFID төхөөрөмжөөр тоноглох, тохиргоо хийх, шилэн кабелин сүлжээнд холбох ажлын хүрээнд гэрээ байгуулсан. Гэрээний хүрээнд 48 дугаар суруулийн урд, Нарны гүүрний баруун талд, Өгөөжийн урд, Бөмбөгөр худалдааны төвийн урд, Гэсэр сүмийн урд, Дөлгөөн нуур худалдааны төвийн урд, Өлзийт төвийн урд, Сансарын түнэлийн бараан, Натурын зам, Нарантуул уулзвар, Олимпын гүүрний хажууд, Баруун 4 зам, Зүүн 4 зам зэрэг нийт 14 уулзварт П хэлбэрийн шонгуудыг камер болон RFID уншигч төхөөрөмжөөр тоноглож, шилэн кабелин сүлжээнд холбох бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна. Улаанбаатар хотыг тойрсон нийт 8 товчоодыг шилэн кабелин сүлжээнд холбосон бөгөөд RFID уншигч төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. /Гүйцэтгэл 70%/


Төслийн үр дүн: Улаанбаатар хотын их тойруу чиглэлийн 14 П хэлбэрийн шон дээр бөгөөд нэмэлтээр Тэрэлж Хоолтын давааны шалган бүртгэх товчоог нэгдсэн шилэн кабелин сүлжээнд холбоно Улаанбаатар хотын их тойруу чиглэлийн 14 П хэлбэрийн шон дээр камер болон RFID тоног төхөөрөмж угсарч суурилуулж, шилэн кабел сүлжээнд холбох бөгөөд нэмэлтээр Тэрэлж Хоолтын давааны шалган бүртгэх товчоог нэгдсэн шилэн кабелин сүлжээнд холбоно.



6. Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний нэгдсэн портал Smartcar.mn 3.0 хувилбарыг нэвтрүүлж, замын хөдөлгөөнд оролцогч нарт зам тээврийн олон төрлийн мэдээлэл өгөх, хөгжүүлэлт хийх

Төслийн явцын мэдээ: "Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний нэгдсэн Smartcar.mn 3.0 шинэ хувилбарт тээврийн хэрэгслийн албан журмын даатгалын мэдээлэл авах үйлчилгээ, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийн мэдээлэх үйлчилгээ, засвартай болон түр хаасан замыг мэдээлэх үйлчилгээ, хэтэвч цэнэглэх дэд бүтцийг үүсгэж, хот хоорондын зам ашигласны хураамж төлөх, замын хөдөлгөөний дүрмийн мэдээллийн санг бий болгож

2022 оны 11 сарын 01-ний өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. Одоо backoffice системийн хөгжүүлэлт, нийтийн тээврийн газрын ачаа тээвэрлэх E,C зөвшөөрөл олгох үйлчилгээ, нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттай оролцуулах түр зөвшөөрөл олгох үйлчилгээ, Ажилчдын автобусны зөвшөөрөл олгох үйлчилгээ, сурагчдын автобусны зөвшөөрөл олгох үйлчилгээг цахимжуулах хөгжүүлэлтийн ажлыг дуусгахаар ажиллаж байна. 12 сарын 15-ны өдөр гэхэд гар утасны аппликейшн update өөрчлөлт нь хийгдэж хэрэглээнд нэвтэрнэ.



Тээврийн хэрэгслийн
нагдсан цахим үйлчилгээ

Нүүр
Таны сонорт ▾
Үйлчилгээ
Таны оролцоо ▾
Смарткарын тухай ▾

Нэвтрэх

Нүүр / Тээврийн хэрэгслийн мэдээлэл


Тээврийн хэрэгсэл

Улсын дугаар **4811УБЭ**

Загвар **Toyota Prius**

Үйлдвэрлэсэн он **2013**

Гэрчилгээний мэдээлэл



Өндөр	Өргөн	Урт	Жин
1,490см	1,745см	4,480см	1,350кг

Арлын дугаар	ZVW305647580
Үйлдвэрлэгч	Toyota
Загвар	Prius
Төрөл	Олон зориулалттай
Үйлдвэрлэсэн улс	Япон
Үйлдвэрлэсэн он	2013
Өнгө	Цайвар ягаан
Импортлогдсон огноо	2018/09/05

Үндсэн цэс

- i Гэрчилгээний мэдээлэл >
- b Оношилгооны мэдээлэл >
- h Даатгалын мэдээлэл >
- % Татвар, хураамж >
- t Торгууль >
- s Ачилт, журамлалт >
- h Хот хоорондын зам ашигласны хураамж >
- b Зогсоолын төлбөр >
- t Төлбөрийн түүх >

Ангилал	В
Хөдөлгүүрийн багтаамж	1797
Араа	-
Шатахууны төрөл	Бензин - Цахилгаан
Жолооны хүрд	Баруун
Суудлын тоо	5

7. Нийслэлийн авто замын гэрлэн дохиотой уулзваруудад RFID уншигч төхөөрөмжүүдийг нийлүүлэх, угсарч суурилуулах, тохиргоо хийх

Төслийн явцын мэдээ: Авто замын гэрлэн дохиотой уулзваруудад RFID уншигч төхөөрөмж суурилуулах шонгийн ажил болон П хэлбэрийн шонгийн суурийн ажил бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд Шонгууд руу татах цахилгааны кабель сувагчлалын ажил нийт




уузваруудын хэмжээнд 80%-тай үргэлжилж байгаа ба шилэн кабель татах ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа бөгөөд RFID үндсэн тоног төхөөрөмжийн суурилуулалт нийслэлийн төвийн зургаан дүүргийн гэрлэн дохиотой **138** уулзварын **114** уулзварт RFID төхөөрөмжийн үндсэн дэд хайрцаг, антен, шилэн кабелийн холболтын ажил 60% хийгдэж байна.

8. Нийслэлийн Дата төвийн мэдээллийн аюулгүй байдал, сервер болон сүлжээний тоног төхөөрөмжийн өргөтгөл

Төслийн явцын мэдээ: Энэхүү төслийн хүрээнд 161 байршилд суурилуулах RFID уншигч төхөөрөмж, систем, шалган бүртгэх 7 товчоодын төлбөр хураалтын болон камерын систем, авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүдийг хэвийн ажиллуулахад шаардагдах сүлжээ болон серверийн тоног төхөөрөмжүүд бүрэн нийлүүлэгдсэн бөгөөд суурилуулахад бэлэн болоод байна. /Гүйцэтгэл 70%/

Төсөл хэрэгжсэнээр хүрэх үр дүн: Нийслэлийн дата төвийн сервер, сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдлын тоног төхөөрөмж суурилагдана. Дата төвийн тоног төхөөрөмж сайжирч, хяналт удирдлагын нэгдсэн системтэй болно.



9. Нэгдсэн мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмж

Төслийн явцын мэдээ: Төслийн хүрээнд нийслэлийн тээврийн цагдаагийн албанд 15 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэх бөгөөд Албан хаагч нар ашиглах бэлэн бус торгуулийн төхөөрөмж /гар утас/, /хэвлэгч/, камерын дүрс, мэдээлэл боловсруулах хяналтын дэлгэц рүү харуулах төхөөрөмж, камерын дүрс, мэдээллийн хяналтын дэлгэц Nas Server, Nas Server-ийн хатуу диск GPU server, RTSP server Rack, Switch зэрэг сервер болон сүлжээний тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдээс нийлүүлэгдсэн бөгөөд албан хаагч нарын энгэрийн камер нийлүүлэгдээгүй хүлээгдэж байна. /Гүйцэтгэл 80%/

Гадна тал



Дотор тал



Төсөл хэрэгжсэнээр хүрэх үр дүн: Цагдаагийн байгууллагын дуудлага мэдээлэл хүлээн авдаг системээр дамжуулан иргэнээс цахимаар дуудлага авах мөн иргэн гар утсанд ирсэн линкээр дамжуулсан видео бичлэг хийх, байршлын мэдээллийг хадгалж дуудлагын дагуу очиж байгаа эргүүлийн алба хаагчдын таблет руу дамжуулах болон мэдээллийг хадгалж мөрдөн шалгах ажиллагаанд нотлох баримт болгож эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах, мөн байршлаа мэдэхгүй, хэлгүй ярианы бэрхшээлтэй иргэдийг цахим сүлжээг ашиглан байршлыг тогтоох боломжтой.

10. Энхтайвны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээг зөрчил илрүүлэх камераар тоноглох

Нийслэлийн энхтайвны өргөн чөлөөний 44 байршилд 1-р эгнээний зөрчил илрүүлэх 45 камераар тоноглож шилэн кабелд холбох, хяналт удирдлагын нэгдсэн системд нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнээс 20 цэгийн 20 камерыг суурилуулсан бөгөөд Замын хөдөлгөөн удирдлагын төвд холбогдон хянагдаж байна. Тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай зарим тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэгч Genetec INC компани нь хагас дамжуулагчийн хомсдолд орсноос болж тоног төхөөрөмж нийлүүлэлтэнд саатал үүсээд байна. /Гүйцэтгэл 70%/

Төслийн үр дүн: 1-р эгнээгээр зөвшөөрөлгүй зорчих тээврийн хэрэгслүүдэд хяналт тавьж, нийтийн тээврийн зорчих хэсгийн ачааллыг бууруулж иргэдийн тав тухтай зорчих орчныг бүрдүүлнэ. Хяналт удирдлагын нэгдсэн системд нэгтгэж "Зам тээврийн ухаалаг нэгдсэн систем"-ийг бий болгоход оршино.

БГД-ийн модны 2 болон тээврийн дээд сургуулийн урд уулзварыг иж бүрэн камержуулалт

Энэхүү ажлын хүрээнд Баянгол дүүргийн Модны хоёрын уулзвар болон Төмөр замын сургуулийн урд уулзварууд дээр 3 цэгт дугаар илрүүлэгч, хурд хэмжигч, улаан гэрлийн зөрчил, эгнээ байрны зөрчил, давхар эргэлтийн зөрчил илрүүлэх камеруудаар бүрэн тоноглохоор шонгийн угсралт, суурилуулалтын ажлын хүрээнд Модны хоёрын уулзварт нийт 17 камер бүрэн суурилуулж ажиллагаанд оруулсан бөгөөд Төмөр замын сургуулийн уулзварын дэд бүтэц кабел, шонгийн суурилуулалтын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж дууссан.

Төслийн үр дүн: БГД -ийн 2 уулзварыг камераар иж бүрэн тоногосноор тус уулзваруудаар нэвтэрч буй тээврийн хэрэгслүүдийн зөрчилийг камерын хяналтаар илрүүлж торгууль ногдуулах, осол аваарийг шуурхай шийдвэрлэх, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах, замын хөдөлгөөний дүрэм журмыг мөрдүүлэх зэрэг үр дүнгүүд гарахаас гадны "Зам тээврийн ухаалаг нэгдсэн систем" ийн камерын хяналтын нэгдсэн системийн суурийг тавина. /Гүйцэтгэл 80%/

